

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 06 дугаар сарын 12

Хөхбүрд

Д/д	Стратеги төлөвлөгөө болон бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
				Хагас жил		
1	2	3	4	5	6	7

Зорилт 1: Хууль эрх зүй, удирдлагын бодлогын хүрээнд

1	1.1.Төрийн албан хаагчдыг чадваржуулах сургалтанд хамруулах	Төрийн албан хаагчдыг чадваржуулах сургалтанд хамруулсан тоо, үр дүнгээр	Удирдлагын академи болон аймаг бүсийн сургалтанд тогтмол хамрагддаг	Чадавхжуулах сургалтад 100%-ын хамрагдсан ирцтэй байх	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд албан хаагчдыг чадавхжуулах 3 удаагийн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулан сургасан. Мөн чиг үүргийн дагуу сургалтанд албан хаагчдыг унаа болон өдрийн томилолтын зардлыг хариуцан суралцуулсан. Нийгмийн бодлогын чиглэлээр 3, Хөдөө аж ахуй 2, байгаль орчин 2, няравын мэргэшил дээшлүүлэх 1 сургалтад тус тус хамрагдсан байна. Урд оныхоос албан хаагчдын сургалтад хамрагдсан тоо 10%-аар өссөн.	90%
2	1.2.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг баталж хэрэгжилтийг хангах,	Хөтөлбөрийг албан байгууллагын албан хаагчдаас санал авч батласан байх, хэрэгжилтийг 100% хангаж тайланг хугацаанд нь баталгаажуулсан байх	Хөтөлбөр баталж 2023 оны байдлаар 100% хэрэгжүүлж, тайлагнаасан.	Хэрэгжилтийг 100% хангаж, хагас жилээр цахим систем болон байгууллагын даргын ёмне тайлагнаж баталгаажуулах	2023 оны 05 дугаар сарын 23-ы өдрийн А/56 тоот Захирамжаар нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг баталж бүх төрийн албан хаагчдад чиглэсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2024 оны байдлаар хөтөлбөрийн дагуу 4 зорилт бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэн хэрэгжилтийг хагас жилийн байдлаар 100% хангаж ажиллаж байна.	90%

Зорилт 2: Архив албан хэрэг хөтлөлтийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

3	2.1.Байгууллагын тусгай төрлийн 2023 оны баримтыг Төрийн архивт шилжүүлэх	Тусгай төрлийн баримтыг төрийн архивт бүрэн шилжүүлснээр	Жил бүр тусгай төрлийн баримтадаа бүрэн шилжүүлдэг	Төрийн архивт тусгай төрлийн 2023 оны баримтыг бүрэн шилжүүлэх	2023 оны 12 дугаар сарын хуваарийн дагуу Төрийн архивын тасагт байгууллагын үйл ажиллагааны гэрэл зургийн цомог-30, наадмын зураг-30 хугацаанд шилжүүлсэн.	90%
---	---	--	--	--	--	-----

1	2	3	4	5	6	7	
4	2.2.Архивын баримтын заавар журмын бүрдүүлж хаагчдаас авах	заавар дагуу албан хүлээн	Ажилтнуудаас архивын баримтыг журмын дагуу хүлээн авснаар	Жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан баримтаяа авч хэвшсэн	Архивын баримтадаа хугацаанд нь ажилтнуудаас бүрэн хүлээн авсанбайх	Байгууллагын 2023 оны архивын баримтадаа албан хаагч нараас хуваарийн дагуу авч байна. Нийгмийн даатгалын байцаагч байхгүй улмаас баримтын аваагүй. Бусад байгууллага цаг тухай бүрдээ өгч дууссан болно.	90%
Зорилт 3: Эдийн засгийн бодлогын хүрээнд:							
5	3.1. Сумын ОНХС, ХХС-аас олгосон зээл, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг оновчтой зохион байгуулж түр болон байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, холбогдох зээлийг төлүүлж ёглөг, авлагагүй байх	Ажлын байрыг нэмэгдүүлж өрхийн орлогыг дэмжих, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн төлөлтийг хуулийн байгууллагад хандаж 90% дээш хувь эргэн төлүүлэх	6 түр буюу улиралын чанартай ажлын байрыг нэмэгдүүлэх	2024 онд түр болон байнгын ажлын байранд ажилласан иргэдийг 5 иргэдээр нэмэгдүүлж өрхийн орлогыг дэмжих	Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлого хагас жилийн байдлаар 61 327 500 (Жаран нэгэн сая гурван зуун хорин долоо таван зуун төгрөг) төвлөрүүлэн ажилласан байна. Үүнээс эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдэж байгаа Асгамба хоршоо 22 360 000, Баянбардан хоршоо 46 844 000, 2012-2016 онуудад авсан иргэн Б.Мөнх-Оргил, Д.Цогтбаатар, Ц.Эрдэнэбат нарын нийт 16 192 500 үлдэгдэл өртэй шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэж ажиллаж байна. Мөн тайлант онд ИТХ-ын тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авах хугацааг товлон, 5 төсөл хүлээн авч, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан боловч шаардлага хангах төсөл ирүүлсэн хоршоо байхгүй байсан тул дахин сонгон шалгаруулалтын тов зарласан байна.	70%	
6	3.2.Төсөвт байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээг цахимаар хийх	Төрийн сангийн төлбөр тооцоог бүрэн цахимжуулах	Цалингийн гүйлгээг цахимаар хийх.	2024 оны 1 дүгээр сарын 02-ний өдрөөс цалингийн болон бусад гүйлгээг 100% цахимжуулж төлбөр тооцоог гүйцэтгэх	Төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог Төрийн сангийн санхүүгийн цахим системээр дамжуулан 100 хувь цахимаар гүйцэтгэж байна. Цахим системтэй холбоотой алдаа зөрчил одоогоор бүртгэгдээгүй, төсвийн байгууллагуудын төсвийн менежер, нягтлан бодогч нар бүрэн чадавхжсан байна.	80%	

1	2	3	4	5	6	7
7	3.3.Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах	ТБОӨБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн иргэн, ААН-ийн оролцоог нэмэгдүүлэх	Тендертэй холбоотой баримт бичгийг цахим хуудсанд байршуулан ажиллах	Сумын тендерийг бүрэн цахимаар зохион байгуулж иргэн, аж ахуй нэгжийн оролцоог нэмэгдүүлэх	Тухайн тайлант онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 4 төсөлт арга хэмжээ, боловсролын байгууллагын хүүхдийн хоолны хүнсний З тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулахаар төлөвлөн, амжилттай зохион байгуулж ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрны хүүхдийн хоолны тендер сонгон шалгаруулалтыг нээлттэй тендер сонгон шалгаруулах журмаар, сурагчдын үдийн хоолны хоол хүнсний тендер шалгаруулалт, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний тендер шалгаруулалтыг тус тус харьцуулалтын аргаар зохион байгуулсан.	70%
8	3.4.Орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх.	Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, тооцоо, судалгаанд үндэслэн төсвийн орлогыг хангах	Орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг татварын нэр төрөл, хугацаагаар жигд ханган биелүүлсэн байна.	Орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг татварын нэр төрөл, хугацаагаар жигд ханган биелүүлсэн байна.	Сумын 2024 оны орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө ёсоор 5 сарын 30-ны байдлаар 915,435.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 940,825 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, нийт орлогын биелэлтийн хувь 103 хувьтай байгаа ба орлогын нэр төрлийн тухайд цалин түүнтэй адилтгах орлогоос суутгах татварын орлого өмнөх оны авлагын дунгзэр давж орсон бол ан агуурын нөөц ашигласны татвар цаг хугацааны хувьд хүлээгдэж байгаа тул тасарсан. Цаашид жилийн эцсийн байдлаар татварын орлогын бүрдүүлэлт давж биелэх төлөвтэй байна	90%
<b>Зорилт 4: Хөдөлмөр эрхлэлт, Халамжийн бодлогын хурээнд</b>						
9	4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлт хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, авлага барагдуулалтыг графикийн дагуу зохион байгуулах.	ХЭДСанд төвлөрүүлсэн мөнгөн дүн, хүний тоо	Тус онд хугацаа хэтэрсэн авлагыг графикийн дагуу барагдуулж ажилласан байна.	2022 онд малжуулах хэтэлбөрт хамрагдсан 5 өрхийн мөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвлөрүүлсэн байна	2022 оны малжуулах төсөлд хамрагдсан асгамба З дугаар иргэн Д.Шааравын 1,500,000 мянган төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлсэн. 2024 оны малжуулах хэтэлбөрт 9 өрхийг 8,000,000 сая нийт 72,000,000 төгрөгийн мал хүлээлцэх ажлын бэлтгэл ажлыг хангаж ажилласан.	90%

1	2	3	4	5	6	7
10	4.2.Сумын СХС, ОНХС, Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүдээр, Бүтээн байгуулалтаар бий болсон шинэ ажлын байрны мэдээ програмд оруулах, мэдээлэх	Тус төсөл хөтөлбөрүүдээр бий болсон шинэ ажлын байрны тоо	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг сум орон нутгийн хэмжээнд сурталчлан хэрэгжүүлэх	Сумын нутаг дэвсгэрт шинээр бий болсон 15-аас доошгүй ажлын байрны мэдээллийг авч програмд оруулж, мэдээлсэн байна.	Малын сэг зэм устгалын нийтийг хамарсан ажлын байранд нийт 22 иргэнийг түр 10 хоногийн ажлын байранд хамруулж ажилласан. Мэдээллийн нэгдсэн системд шинэ түр ажлын байраар бүртгэсэн. Нийтийг хамарсан түр ажлын байранд 22 иргэн, байнгын ажлын байранд 16 иргэнийг үүнээс шинэ ажлын байранд 5 иргэн, улиралын шинэ ажлын байранд 1 иргэнийг тус тус зуучилсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 39 иргэнийг түр болон байнгын ажлын байранд зуучилсан	80%
11	4.3.Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Зөвлөгөө мэдээлэл өгсөн иргэдийн тоо, сургалт, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо, Хөдөлмөрийн хуулийн дагуу үзлэг шалгалтыг хийж	Сумын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх	Сургалт арга хэмжээ 2 удаа, үзлэг шалгалт 1 удаа зохион байгуулсан байна. хяналт тавьж ХБИ ажиллуулаагүй ААН-үүдээр зохих төлбөрийг төлүүлсэн байна.	Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүд уурын зууханд хяналт хийж нийт ажил олгогч наарт сургалт мэдээллийг өгсөн. Сарын аяны хүрээнд үйлдвэрлэлийн осол хурц хордлого түүнийг судлан бүртгэх орон тооны бус байнгын зөвлөлийн талаарх сургалтыг нийт 65 албан хаагчдад хийсэн	80%
12	4.4.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусlamжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн анхан шатны баримт материалыг хүлээн авч хувийн хэрэг нээж, баяжилтийг хууль, журмын дагуу тухай бүр нь хийж иргэнд үйлчилгээг хүргэх.	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах нөхцлийг хангасан иргэдэд үйлчилгээ үзүүлж, иргэн бүрд анхан шатны материалыг бүрдүүлэн хувийн хэргийн бүрдлийг хангаж ажилласан байна.	2024 оны байдлаар үйлчилгээ авах иргэдийн хүсэлт ирээгүй бөгөөд бэлтгэл байдлыг хангасан.	Ehalamj, WAIS программыг ашиглан үйлчилгээг түргэн шуурхай хүргэж ажилласан байна.	Эхний 5 сарын байдлаар 1.694 хүнд 693.429.003 мянган төгрөгийг мөнгөн тусlamжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож ажилласан.	90%

1	2	3	4	5	6	7
Зорилт 5: Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны хүрээнд						
13	5.1.Газар тариалангийн салбарын үйл ажиллагааг дэмжиж, тариалалт, тэжээлийн ургамал тариалалтыг дэмжих	Нийт тариалалт хийгдсэн талбай, хураан авсан ургацын хэмжээгээр	Сумын хэмжээнд төмс хүнсний ногоо тариалалтыг 5 хувь, тэжээлийн ургамлын хангарт 100 хувьд хүргэсэн байна.	ААН-д газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн тариалалтыг 50%-д хүргэсэн байна.	Tөмс 5 га, манжин 2 га, лууван 1.5 га, Байцаа 0.4, Өргөст хэмх, улаан лооль 0,002 га, Хүрэн манжин 0.5 га, сонгино 8 га, чинжүү 0.001 га, чацарагана 6 га нийт 23.005 га талбайд тариаланчидасаа авч нэгтгэн газар тариалангийн хэлтэст хүргүүлэн ажиллав.	70%
14	5.2.“Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Үзэсгэлэн худалдаанд оролцогч үйлдвэрлэгчдийн тоо, нийт орлого	ЖДУ, хоршоо, аж ахуйн нэгжүүдэд сургалт зохион байгуулагдана	10-с дээш жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалан эрхлэгчийг хамруулна.	2024.01.02 9 дүгээр сард зохион байгуулагдана.	
15	5.3.Малын ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийг дээрээс өгсөн хяналтын тооны дагуу бүрэн хийж хэрэгжүүлэх	Нийт тухайн жилд ээмэглэж, бүртгэлжүүлсэн малын тоо	Ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэд 20 хувьтай хэрэгжсэн.	Малын ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийг нэгдсэн программд 65 хувьд хүргэнэ.	Мал аж ахуйн нэгдсэн системд Үхэр 11, хонь 754, ямаа 57 нийт 822 малыг ээмэгжүүлэн шивэлтийг хийж ажилласан байна.	90%
16	5.4.Малыг эрүүлжүүлэх, удмын санг сайжруулах, нутгийн шилмэл омог үүлдэрийн малыг өсгөн эдийн засгийн эргэлтэд оруулж, таваарлаг чанарыг сайжруулна	Удмын санг сайжруулах, бодлогоор дэмжиж ажилласан байна.	Үүлдрийн цөм сүрэг өсгөж байна.	Цөм сүрэг өсгөх малчдын тоо 30%-аар нэмэгдсэн байна.	2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/48 дугаар Захирамжаар Засаг дарга Г.Ганцож, Хөдөө аж ахуйн тасгийн дарга Л.Гүндцамба, Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга Т.Цэцэгсайхан, Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга С.Энх-Амгалан, Асгамба 3 дугаар багийн Засаг дарга М.Сэр-Од, Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга Б.Дагдансүрэн нартай ажлын хэсэг Мандалхайрхан 1 дүгээр багийн малчин Д.Төмөрбаатарынд хүц 121, ухна 152, В.Даваасүрэн хүц 200, ухна 181, Уранхайрхан 2 дугаар багийн малчин И.Нямпүрэв хүц 123, ухна 156 гэсэн малчин өрхүүд ухна хүц хариулах малчинтай турвалсан гэрээ байгуулан ажилласан.	90%

1	2	3	4	5	6	7
17	5.5. Хүнсний худалдаа, үйлдвэр, үйлчилгээний газруудад Цагаан сар, Хүүхдийн баяр, Улсын баяр наадам, Шинэ жил зэрэг нийтийг хамарсан баяр ёслолын үеэр хяналт шалгалт хийх	Улиралд бүр хяналт шалгалт зохион байгуулна.	4 удаагийн хяналт шалгалт зохион байгуулсан	Улирал бүр хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулж ажилласан байна	2024 оны 04 дүгээр сарын 15-нд Аймгийн Эрүүл мэндийн төвийн Улсын байцаагч Б.Баасанцэрэн "Хүнсний аюулгүй байдал" З сарын аян зарлагдсанаар Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам, Салбарын хяналтын газар, Улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/13 төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд сумын хүнсний худалдааны 4 объектийг хамруулан 14 нэр төрлийн 27 ширхэг 87 250 төгрөгний хадгалалтын горим алдагдсан, хэрэглэх хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлэн хэрэглэгчидэд нийлүүлэхээс урьдчилан сэргийлж, устгуулах арга хэмжээг авч, зөрчил гаргасан 3 аж ахуй нэгжүүдэд 6 заалт бүхий албан шаардлага, зөвлөмж хүргүүлж, холбогдох хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.	90%
18	5.6. Мал аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэлийг зохион байгуулах	Өвөлжилтийн бэлтгэлийн 85-аас доошгүй хувь хангасан байна.	2023-2024 онуудад өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах.	Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг 35-с дээш хувь хангасан байна.	8-аас 9 саруудад хэрэгжинэ.	0%
Зорилт 6: Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:						
19	6.1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг технологит хугацаанд тархвар зүйн зураглалтын дагуу зохион байгуулсан ажиллах	Төлөвлөгөөт дархлаажуулалтанд хамрагдах мал сүргийн 90-ээс доошгүй хувийг хамруулж мал амьтны халдварт өвчний гаралтыг өмнөх оныхос бууруулсан байна.	119250 толгой малыг хамруулж төлөвлөгөөт ажлыг 100 хувиар биелүүлсэн.	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтийг мал эмнэлгийн нэгдсэн системд 100% оруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гүйцэтгэл хамруулах	Сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/27 дугаар захирамжийн Нэгдүгээр хавсралтаар байгуулагдсан (Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах) ажлын хэсэг дархлаажуулалтыг хийж ажиллаа. Сумын нийт 687 өрхийн 90000 толгой хонь дархлаажуулалтанд хамруулахаас 687 өрхийн 89700 хонь буюу 100 хувьтай дархлаажуулалтанд хамруулах ажлыг хийж гүйцэтгээд байна. (Улсын төсвөөс санхүүжүүлэх Бoom-20200, Галзуу-21300, Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх Коли иж балнад-6000, Тугалын иж балнад-2400, Дотрын халдварт хордлого-30 000, Цусан халдварт-7200, Иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэх	90%

1	2	3	4	5	6	7
19					Сохор догол-7000, Шөвөг яр-3200, Сахуу-150 толгой мал нийт-97450 мал буюу 56 хувьд нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэн хийгдэх вакцин)-ыг100% оруулж, Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл 60%-тай хамруулж, Мал, амьтны шимэгтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх (Угаалга бод 3417, бод 97796, Туулгалт бод 1880, бод 92000, Нохой 140, Боловсруулалт бод 683, бод 34461 гэх мэт) арга хэмжээний төлөвлөлтийг мал эмнэлгийн нэгдсэн системд 100% оруулсанаас нийт давхардсан тоогоор 216719 толгой мал хамруулахаас 200291 мянган толгой мал буюу 92 хувь хамруулах ажлыг Мандалхайрхан 1 дүгээр багт малын их эмч Т.Энх-Амгалан, Уранхайрхан 2 дугаар багт малын эмч Б.Лхагвасүрэн, Асгамба 3 дугаар баг, Мэргэн 4 дүгээр багт малын их эмч Ц.Дандар гүйцэтгэж байна.	
20	6.2. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг /Угаалга, Туулга, Боловсруулалт/ 4 багийн хэмжээнд нийт мал сүргийг хамруулан чанартай зохион байгуулан ажиллах.	Шимэгчтэх өвчний гүйцэтгэлд анхаарч, халдвэрлалтын түвшинг өмнөх оньхиос бууруулах	2023 онд дахардсан тоогоор 200219 мянган толгой мал амьтныг хамруулан гүйцэтгэл 92 хувьтай ажилласан байна.	Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтийг мал эмнэлгийн нэгдсэн системд 100% оруулж, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл 20%-тай хамруулах.	Сумын мал, амьтны шимэгчтэх өвчинтэй тэмцэх 2024 оны мал эмнэлгийн тасгийн төлөвлөгөөт 4 (дөрвөн)арга хэмжээг боловсруулан сумын Иргэдийн төлөөлөгчдүүн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 12/07 дугаар тогтоолоор баталгаажуулан сумын 4 багийн хэмжээнд Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх (Угаалга бод 3861, бод 64531, Туулгалт бод 1791, бод 64531, Нохой 140, Боловсруулалт бод 683, бод 12669 гэх мэт) арга хэмжээний төлөвлөлтийг мал эмнэлгийн нэгдсэн системд 100% оруулсанаас нийт давхардсан тоогоор 72204 толгой мал хамруулахаас 28882 мянган толгой мал буюу 40 хувь хамруулах ажлыг Мандалхайрхан 1 дүгээр багт малын их эмч Т.Энх-Амгалан Уранхайрхан 2 дугаар багт малын эмч Б.Лхагвасүрэн, Асгамба 3 дугаар баг, Мэргэн 4 дүгээр багт малын их эмч Ц.Дандар нар төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэж байна.	90%

1	2	3	4	5	6	7
21	6.3. Мал, амьтны сэг зэм устгал, бэлчээр, хашаа хороог стандарт зааврын журмын дагуу халдвартайгүйтгэл хийж гүйцэтгэх	Халдварт өвчинеес урьдчилан сэргийлэх	2023 онд 5290 м <sup>2</sup> талбайд хийж гүйцэтгэсэн.	Шаардлагатай халдвартайгүйтгэл тухай бүрт хийж гүйцэтгэсэн байна.	Сумын Засаг даргын захирамжын дагуу Мал, амьтны сэг, зэнийг устгах, орчны халдвартайгүйтгэл хийх ажилд оролцогч талуудын хамтын ажиллагаа, үүрэг, оролцоог тодорхой болгож Сэг зэм устгах, орчны цэвэрлэгээ ариутгал, халдвартайгүйтгэлийн арга хэмжээг сум, багийн хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээ явуулж байгаа гурван аж ахуйн нэгжийн гурван малын эмч, мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч, тархвар зүйч нийт 6 малын эмч, сумын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн буюу төсөвт байгууллагитийн 92 төрийн албан хаагч, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, малчдын төлөөлөл нийт 40 иргэн, 34 авто машинтай зохион байгуулсан, сум орон нутгаас 909 шатахууны 3 500 000 төгрөг, бусад зардал 29 990 000 төгрөг нийт 33 490 000 төгрөгийн (халдвартайгүйжүүлэлтийн үйл ажиллагаанд шаардлагатай бодис, уусмалын тооцоог гаргаж, татан авч, малын эм, эмнэлгийн хэрэгсэл, халдвартайгүйжүүлэлтийн зарцуулсан зардал, зарцуулсан тоо мэдээний үр дүн зэргийг ЗДТГ-ын санхүү алба тооцон тайлагнах ажлыг сумын Онцгой комиссоор хэлэлцүүлэн аймгийн Онцгой комиссийд хургэх ажлыг зохион байгуулав.	100%
22	6.4. Мал, амьтны халдварт өвчинеес урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг технологит хугацаанд тархвар зүйн зураглалтын дагуу зохион байгуулсан ажиллах	Төлөвлөгөөт дархлаажуулалтанд хамрагдах мал сүргийн 90-ээс доошгүй хувийг хамруулж мал амьтны халдварт өвчиний гаралтыг өмнөх оныхос бууруулсан байна.	119250 толгой малыг хамруулж төлөвлөгөөт ажлыг 100 хувиар биелүүлсэн.	Мал, амьтны халдварт өвчинеес урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтийг мал эмнэлгийн нэгдсэн системд 100% оруулж, халдвартайгүйтгэл хамруулахад 30% хамруулах	Сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/27 дугаар захирамжийн Нэгдүгээр хавсралтаар байгуулагдсан (Малын гоц халдвартайгүйтгэл хамруулахад 30% хамруулах) ажлын хэсэг дархлаажуулалтыг хийж ажиллаа. Сумын нийт 687 өрхийн 90000 толгой хонь дархлаажуулалтанд хамруулахаас 687 өрхийн 89700 хонь буюу 100 хувьтай дархлаажуулалтанд хамруулахад 30% хамруулах	90%

1	2	3	4	5	6	7
Зорилт 7: Гамшигийн үеийн бэлтгэл бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:						
	7.1. Гамшигаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан тодотгол хийж бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажиллах	Төлөвлөгөөний дагуу арга зүйгээр хангах	2023 онд төлөвлөгөөн тодотгол хийгдсэн	Эхний хагас жилд: Гамшигаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулсан байна.	Баян-овоо сумын мал эмнэлэгийн тасгийн мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний үед шуурхай хэрэгжүүлэх бэлэн байдлын 16 нэр төрлийн ажил үйлчилгээ хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан тодотгол хийж сумын Шуурхай штабын даргаар баталгаажуулан бэлэн байдлыг хангах ажлыг хийж гүйцэтгэж байна.	70%
23	7.2. Аж ахуйн нэгж, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх, иргэдэд түргэн шуурхай хүнд суртал, чирэгдэлгүй мэдээллийг хүргэх, Иргэдээс МЭТ-т гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Аж ахуйн нэгж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэн хариуг тухай бүр хүргүүлсэн байна.	2023 онд аж ахуйн нэгж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй	Эхний хагас жилд: Иргэдээс төрийн гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хугацаа хоцорсон асуудал 0 байх.	2024 оны хагас жилийн байдлаар Засаг даргын тамгын газарт 20 өргөдөл, бусад байгууллагат 18 өргөдөл ирснийг и-оффист цахимаар бүртгэн 1 сарын дотор хариуг хүргүүлэн шийдвэрлэж, 1,2 дугаар улирлын мэдээг нэгтгэн албан бичгээр төрийн захиргаа, удирдлагын хэлтэс хүргүүлсэн. Мөн цахим мэдээллийн сайтад байршуулан ажиллаж байна. Хагас жилийн байдлаар мал эмнэлгийн тасагт өргөдөл гомдол ирээгүй болно.	100%
Зорилт 8: Нийгмийн салбарын уялдаа холбоог хангах, хэрэгжүүлэх						
24	8.1. Нийгмийн салбаруудын дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дээд шатны байгууллагад хүргүүлэх,	Хяналтанд авсан хөтөлбөрийн тоо, хэрэгжилтийн хувь	2 дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд төлөвлөгөөнд оруулан хяналтад авч ажиллаж байна.	Хагас жилийн байдлаар 50-аас дээш хувиар дүгнүүлэн хэрэгжилтийг тайлagnах	Жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс 2023 оны иргэдийн төлөөлөгчдийн анхдуугаар хурлаар жендерийн салбар хороог шинэчлэн байгуулж төлөвлөгөөг хагас бүтэн жилээр цаасаар болон төрийн мэдээллийн сүлжээнд цахим байдлаар 80%-тай тайлagnаж ажилласан.	80%

1	2	3	4	5	6	7	
25	8.2. Сумын Хамтарсан багийн ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулах, багийн гишүүдийн үүрэг оролцоог сайжруулах,	Нууцын гэрээ байгуулсан байх, Нэлэөллийн 1 сайн ажил зохион байгуулах, Үйлчилгээ авсан иргэдийн тоо ихсэх, Гарсан зөрчил буурах	Хамтарсан багийн гишүүдийг чиглүүлж, төлөвлөгөө боловсруулсан	Хамтарсан багийн ажлыг хагас жилийн байдлаар 50-аас дээш гүйцэтгэсэн байх	Хамтарсан багийн шинэчлэгдсэн гишүүдийн нууцын гэрээг тухай бүр хурлаар оруулан тухайн албан хаагчтай байгуулан ажиллаж байна. 2024 оны байдлаар 2 гишүүнтэй шинээр нууцын гэрээ байгуулж ажилласан. 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/39 дугаар тоот Захирамжаар хамтарсан багийн хурлын тов болон ажиллах журмыг хэлэлцүүлэн баталж ажиллаж байна. Хамтарсан багийн төлөвлөгөөг улирал бүрээр батлан хэрэгжилтийг тайлагнаж ажиллаж байна.	90%	
Зорилт 9: Цахим гарын үсгийн олголтыг сайжруулах, төлөвлөн хэрэгжүүлэх.							
26	9.1.Иргэдэд цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	400 иргэнд Тоон гарын үсэг олгосон байх	2023 оны байдлаар зорилтот 1644 иргэнээс 1394 хүнд олгож 84.7 хувьтай байна.	200 иргэнд олгож, 50%-тай гүйцэтгэсэн байх	Иргэдэд цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, тоон гарын үсэг олгох ажлыг төлөвлөн хагас жилийн байдлаар 220 иргэнд тоон гарын үсэг олгож, сумын хэмжээнд нийт 1875 иргэнд олгож 86%-тай олголт хийсэн байна.	90%	
Зорилт 10:Байгаль орчныг хамгаалах, хяналтыг сайжруулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд.							
27	10.1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийн сайжруулах, нэмэгдүүлэх	Сумын хэмжээнд 20.000 аас дээш тооны мод тарьсан байх	27.000 2022 тарьсан	мод онд	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Сумын хэмжээнд “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний төсвийн байгууллагууд, албан хаагчид, төгсөх ангийн сурагчид, нийт ард иргэдийг бүх нийтээрээ мод тарих орчинoo сайжруулах аяныг зохион байгуулан уриалан ажилласан. Сумын хэмжээнд хаврын мод тарилтаар нийт 7 төрлийн 387 ширхэг мод тарьж ургуулсан. Сумын төвийн төсвийн байгууллагуудын эзэмшлийн талбай дахь ногоон байгууламжийн хайс хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулан Засаг даргын тамгын газар нийт 2 га талбайд 450метр төмөр хайсжуулалт, Ерөнхий боловсролын сургууль 360метр төмөр хайсжуулалт, Цэцэрлэг 380 метр модон хайсжуулалт, Шинэ музейн барилгыг Соёлын төвийн байгууллага хариуцаж 270метр төмөр хайсжуулалтыг тус тус шинээр хийж гүйцэтгэн өнгө үзэмжийг сайжруулан, ногоон байгууламжийн хамгаалалтыг нэмэгдүүлэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулан ажилласан.	90%

1	2	3	4	5	6	7
28	10.2. Ариун цэврийн байгууламжийг сайжруулах, эко жорлон, шаардлага хангасан нүхэн жорлонг байгуулах, ашиглах	2-оос доошгүй шаардлага хангасан нүхэн жорлонтой болох	Шаардлага хангасан байгууламж байхгүй	Шаардлага хангасан нүхэн жорлон ашиглах хэвшлийг нийтэд тогтоосон байх	<p>Сумын төвийн модон жорлонгийн тоог цөөлөх, эрүүл аюулгүй байдлыг бий болгох зорилго тавьж төв суурин газруудын айл өрхийн нүхэн жорлонгийн судалгаа авах, эрсдэл аюултай болон энгийн, шаардлага хангасан гэсэн 3 төрөлд бүртгэж ажилласан. Эхний ээлжид иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор 78 төрийн албан хаагчид, 39 иргэдийг сургалт мэдээллээр хангасан. Мөн албан байгууллагын нүхэн жорлонг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг эхлүүлж ЕБСургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв газруудад ариутгах таттуургын дотор нойлтой болгосон. Нүхэн жорлонгийн аюулгүй байдал, амрах таатай эрүүл нэхцлийг байгуулах уриалга, шаардлага, анхааруулга, мэдээллийн арга хэмжээг иргэд, албан байгууллагын дунд 1 удаа авч хэрэгжүүлсэн. Сумын хэмжээнд 3 байгууллага дотор ариун цэврийн байгууламж, 5 байгууллагын 5 нүхэн жорлон, 12 айлын модон жорлонг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар бүртгэгдсэн байна.</p> <p>Эхний хагас жилийн байдлаар Соёлын төв, Стадион, Шинэ хашаа хорооллын өрхүүдээс 8 өрхөд нийт 10 эко ариун цэврийн байгууламжийг байгуулахаар ажлыг эхлүүлээд байна.</p>	70%

1	2	3	4	5	6	7
29	10.3. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэн хог хаягдлыг ангилан ялгах хэвшлийг бий болгох, нөхцөл боломжийг хангах	Хог хаягдлын ангилан ялгах 5-аас доошгүй түр цэгийг байгуулах	Нийт 5 ширхэг ангилан ялгах хог хаягдлын сав сумын хэмжээнд бүртгэсэн	Ангилан ялгах хэвшлийг эх үүсвэр дээр нь таталжуулсан байх	2024 оны эхний хагас жилд цаг үеийн нөхцөл байдал, цас зудтай холбоотой малын сэг зайлзуулах болон нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг Голийн ай сав газар болох Хөхбурд нуур, Нарийн гол, бэлчээрийн талбайг 6-н байгууллагын 182 албан хаагч болон малчин ард иргэдтэйгээ хамтарч сэг зэмийг цэвэрлэсэн. Булгийн хог хаягдлыг 6 байгууллагын 187 төрийн албан хаагч 320 га газрыг цэвэрлэж нийт 14,5 тонн хог хаягдлыг цэвэрлэж тус сумын хогийн цэгт зайлзуулан ажилласан. Нийт хог хаягдлын цэвэрлэгээнд нийт 1108800 төгрөгийг бензин түлш, хоол унданд зарцуулан ажилласан Сумын хэмжээнд хуванцар сав, нийлэг уут дахин ашиглах, нийлүүлэх зорилгоор Даян дуулим ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж 6 төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлэн ажиллаж байна. Дээрх ажлыг сумын хэмжээнд амжилттай хэрэгжүүлэх, дадал хэвшлийг бий болгох зорилгоор ангилан ялгах хог хаягдлын савыг нийтийн эдэлбэр газрын 6 байршилд байгуулж, нийт 12 албан байгууллага аж ахуй нэгжийг зориулалтын ангилан ялгах хог хаягдлын сав байрлуулах хугацаатай шаардлагыг өгч ажилласан.	70%


 ХЯНАСАН  
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
 ДАРГА *[Signature]* М.ЖАВЗАНСҮРЭН  
 ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН  
 НИЙГМИЙН БОДЛОГЫН  
 МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Θ.АРИУНЗАЯА